

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТАГТ ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ
БҮРДЭЭГҮЙ, ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

АУДИТЫН КОД: ГСА-2026/14-6-ШТА-НА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа, Утас: 70543156,
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179 Цахим
хаяг: Ankhtuyab@audit.gov.mn

Говьсүмбэр аймаг

2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Анхтуяа

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор
С.Батцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:
Говьсүмбэр аймаг, Сүмбэр
сум, 3 дугаар баг, Нутгийн
удирдлагын ордон, 205 тоот

2026 оны 05 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГС 3

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдээгүй байна. 7

1.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн сангийн бүтэц, зохион байгуулалт Төсвийн тухай хуультай нийцээгүй байна. 7

Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа боловч санхүүжилт, зарцуулалтын эрх олголт, төлбөр тооцоотой холбоотой нийтлэг зөрчлүүд давтагдсан байна. 13

2.1. Орон нутгийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу бүрэн олгоогүй, зарцуулалтын эрх олголт журмын шаардлагад нийцээгүй байна. 13

2.2. Аймаг, сумдын төрийн сан төлбөр тооцооны хяналтад санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлтийг харилцан адилгүй ойлгож, ялгаатай байдлаар хэрэгжүүлсэн байна. 16

2.3. Аймгийн СТСХ, сумдын санхүүгийн албанд төлөвлөгөөт хяналтууд хийгдэж байгаа боловч өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, ижил төрлийн зөрчил давтагдсан нь дотоод хяналт үр нөлөөгүй байгааг илтгэж байна. 20

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

БХЭ	Барьцаа хөрөнгийн эрх олгох
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГСУМС	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЭБ	Санхүүжилтийн эрхийн баталгаа
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТАГ	Төрийн аудитын газар
ТСУЦС	Төрийн сангийн удирдлагын цахим систем
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар баталсан 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөөг үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл” сэдэвт аудитын хүрээнд дүгнэлт, зөвлөмж боловсруулж, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Аудитын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ.

1. Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх
2. Төрийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын Санхүүгийн алба болон Төрийн сангийн удирдлагын цахим системийг ашигладаг бусад төрийн байгууллагын 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр нөлөөг хамруулан шалгав.

Аудитын арга зүй: шалгуур үзүүлэлт:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан ТАБ-аас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглав.

- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн сангийн үйл ажиллагааны журам /2023 оны 444 дүгээр тогтоол/
- Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт /2012 оны 294 дүгээр тушаал/
- Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг заавар /2016 оны 431 дүгээр тушаал/
- “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, “төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”, “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал /2025 оны 112 дугаар тушаал/
- “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар” /2015 оны 90 дүгээр тушаал/
- “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам” /2014 оны 65 дугаар тушаал/

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

- “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар” /2024 оны 254 дүгээр тушаал/
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар /2024 оны 256 дугаар тушаал/
- Төрийн сангийн цахим системийн заавар /2024 оны 255 дугаар тушаал

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Анхтуяа, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын нээлтийг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 05 дугаар сарын 26-ны дотор боловсруулан, дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл:

“Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргах” 2, “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвт гүйцэтгэлийн аудит 1, нийт 3 аудитын хугацаа давхацсантай холбоотойгоор аудитыг багаар гүйцэтгэхэд хүн хүчний хувьд дутагдал үүссэн.

Аймгийн хэмжээнд төрийн сангийн үйл ажиллагааг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын Санхүүгийн алба гэсэн бүтэц, зохион байгуулалтаар хэрэгжиж байна.

ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ

2026 оны байдлаар төрийн сангийн чиг үүргийг нийт 10 албан хаагч хэрэгжүүлж байгаагаас аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст төрийн сангийн тооцооны мэргэжилтэн 1, Шивээговь сумын Санхүүгийн албаны дарга 1, нийт 2 орон тоо сул байна.

Аймгийн хэмжээнд төрийн санд нийт 341 данс бүртгэлтэй байна. 2023-2025 онд төрийн сангийн дансаар 18.9-39.5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан бол 91.0-124.5 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Орон нутгийн төрийн сангийн бүтэц	7
Дүрслэл 2	Аймаг, сумдын төрийн сангийн албан хаагчдын орон тооны судалгаа	8

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №01	Аймаг, сумдын төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын судалгаа	9
Хүснэгт №02	Аймгийн хэмжээнд 2023-2025 онд олгосон санхүүжилт	12
Хүснэгт №03	2023-2025 онд олгосон нэмэлт төсвийн зарцуулалтын судалгаа	15
Хүснэгт №04	2023-2025 онд аймгийн хэмжээнд хийгдсэн гүйлгээний тоо, зарлагын гүйлгээний мөнгөн дүн	16
Хүснэгт №05	2023-2025 онд аймгийн хэмжээнд хийгдсэн гүйлгээнээс буцаасан шалтгаан	17
Хүснэгт №06	Орлого бууруулах гүйлгээний ангилал	18-19
Хүснэгт №07	Орлого бууруулсан гүйлгээний түүврийн жагсаалт	19
Хүснэгт №08	2023-2025 онд сумдын Санхүүгийн албанд дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмж	20

БҮЛЭГ 1

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдээгүй байна.

1.1.2 Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэр гараагүй байна.

2023-2025 онд төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой аймаг, сумдын ИТХ болон Засаг даргын холбогдох шийдвэр гараагүй байна.

1.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн сангийн бүтэц, зохион байгуулалт Төсвийн тухай хуультай нийцээгүй байна.

1.2.1. Орон нутагт төрийн сангийн бүтэц, зохион байгуулалт оновчтой бүрдээгүй, мэргэшсэн хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д төрийн сангийн үйл ажиллагааг төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагаа гэж тодорхойлсон. Мөн хуулийн 35-38 дугаар зүйлд төрийн сангийн нэгдсэн данс, тогтолцоо, нийтлэг чиг үүрэг болон Төв төрийн сангийн чиг үүргийг хуульчилсан байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т “Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын тамгын газрын дэргэд, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан нь тухайн шатны захирагчийн ажлын албаны дэргэд байна” гэж заасан.

Дүрслэл №01 Орон нутгийн төрийн сангийн бүтэц



Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор сумдын Санхүүгийн алба байгуулагдсан байна.

Одоогийн бүтцээр аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон сумдын Санхүүгийн алба нь тухайн шатны Засаг даргын тамгын газрын хэвтээ тогтолцоонд харьяалагдан ажиллаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуульд заасан “тухайн шатны Засаг даргын тамгын газрын дэргэд байна” гэсэн зохицуулалттай нийцэхгүй бөгөөд санхүүгийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхэд дараах эрсдэлийг бий болгож байна.

Тухайлбал:

- ТЕЗ буюу (Засаг дарга) болон түүнд хяналт тавих ёстой байгууллага (аймгийн СТСХ) нэг бүтцийн хүрээнд ажиллаж байгаа нь хяналтын хараат бус байдал алдагдах
- Төрийн сангийн нэгдсэн бодлогын хэрэгжилт орон нутагт хэвтээ, босоо бүтцийн дунд саатаж удаашрах
- Төрийн сангийн үндсэн чиг үүрэг болох төлбөр тооцооны хяналт, санхүүгийн тайлагналд зориулах цаг хугацаа багасаж, ажлын чанарт сөргөөр нөлөөлөх

- Орон нутгийн сонгуулийн үр дүнгээс хамаарч, улс төрийн шалтгаанаар хэлтсийн дарга, мэргэжилтнүүд тогтвор суурьшилгүй ажиллах, мэргэшсэн хүний нөөцийн бодлого алдагдах

Иймээс Төсвийн тухай хууль болон холбогдох эрх зүйн актад аймаг, сумын төрийн сангийн удирдлага, харьяаллын тогтолцоог илүү тодорхой тусгаж, “дэргэд” болон “харьяанд” ажиллах ойлголтын ялгааг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Дүрслэл №02 Аймаг, сумын төрийн сангийн албан хаагчдын орон тооны судалгаа



2026 оны байдлаар аймаг, сумын төрийн санд нийт 10 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 2 орон тоо сул байна. 2023–2025 онд хүний нөөц тогтвор суурьшилгүй, нийт 14 удаагийн өөрчлөлт гарсан байна. Тухайлбал, энэ хугацаанд Шивээговь суманд төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь Санхүүгийн албаны даргын, Баянтал суманд Санхүүгийн албаны дарга нь төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэсэн. Сумдын түвшинд тухайн албан тушаалд тавигдах шаардлага, шалгуурыг хангасан мэргэшсэн хүний нөөц хомс байгаа нь цалин хөлсний түвшин болон боловсон хүчний хүрэлцээтэй холбоотой байна.

Хүний нөөцийн хүрэлцээ, тогтвортой байдал хангалтгүй, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн их байгаа нь ажил үүргийн давхардал үүсэх, нэг албан хаагч олон чиг үүргийг хавсран хэрэгжүүлэх, улмаар дотоод хяналт сулрах нөхцөлийг бүрдүүлж байна.

Тухайлбал, Шивээговь сумын Санхүүгийн албаны даргын сул орон тоо өнөөдрийг хүртэл нөхөгдөөгүй байгаа нь хууль, дүрэм, журам болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд эрсдэл үүсгэж байна.

Мөн Сүмбэр сумын Санхүүгийн албаны даргын албан тушаал Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолд ТЗ-7 ангилалд хамаарахаар заасан байхад ангиллыг ахиулж ТЗ-6-аар үндсэн цалинг тогтоосны улмаас 1 сарын үндсэн цалинг 154.0 мянган төгрөгөөр илүү тооцож, 1–4 дүгээр сард нийт 1.6 сая төгрөгийн цалинг илүү олгосон нь 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоох үндэслэл болсон.

1.2.2. Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг нийтлэг чиг үүргүүдтэй нийцэж байгаа боловч аймаг, Сүмбэр сумын ЗДТГ албан тушаалын тодорхойлолтоо шинэчлэн батлуулаагүй байна.

Хүснэгт №01 Аймаг, сумдын төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын судалгаа

Аймаг, сумын нэр	Хуучин мөрдөгдөж байсан тушаал, шийдвэр (2019 оны ТАЗ-ийн 03 дугаар тогтоолыг үндэслэсэн)	Шинэчлэгдсэн нөхцөл байдал (2025 оны ТАЗ-ийн 208 дугаар тогтоолыг үндэслэсэн)	Тайлбар
Аймаг	Аймгийн ЗДТГ 2022 оны А/39, 40	Шинэчлэхээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.	
Сүмбэр сум	Сүмбэр сумын ЗДТГ 2019 оны А/37	Шинэчлэхээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.	
Шивээговь сум	Шивээговь сумын ЗДТГ 2020 оны А/01	Шивээговь сумын ЗДТГ 2025 оны А/150	Шинэчлэн баталсан
Баянтал сум	Баянтал сумын ЗДТГ 2020 оны А/01	Баянтал сумын ЗДТГ 2025 оны А/114	Шинэчлэн баталсан

Эх сурвалж: Аймаг, сумдын ЗДТГ-ын хүний нөөцийн мэдээлэл

ТАЗ-ийн 2025 оны 208 дугаар тогтоолын дагуу Шивээговь, Баянтал сумын ЗДТГ албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан байна. Харин аймгийн ЗДТГ болон Сүмбэр сумын ЗДТГ албан тушаалын тодорхойлолтоо шинэчлэн батлуулахаар ТАЗ-д хүргүүлсэн боловч одоогоор хариу ирээгүй байна. Аймаг, сумын төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусгасан чиг үүргүүдтэй холбоотой цаашид анхаарах дараах нийтлэг асуудлууд байна.

- Аймгийн СТСХ-ийн 4 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өдөр тутмын хэрэгжүүлэх шинжтэй ажлуудыг чиг үүрэгт тусгасан нь албан тушаалын үндсэн чиг үүргийг оновчтой, ялгамжтай тодорхойлоогүй байна. Энэ нь албан тушаалын үндсэн чиг үүрэг болон ажил үүргийн хуваарилалт тодорхой бус болох, чиг үүргийн давхардал үүсэх, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт оновчгүй байх эрсдэлтэй байна. */Ерөнхий санхүүч, Бүртгэл, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, Төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Төрийн сангийн тооцооны мэргэжилтэн/*
- Сумдын Санхүүгийн албаны даргын албан тушаалын тодорхойлолт дахь чиг үүргийг жишиг зааврыг баримтлан тусгасан боловч өдөр тутмын шинжтэй ажлуудыг үндсэн чиг үүрэг болгон хэт жижиглэн задалсан, албан тушаалд үл хамаарах чиг үүргийг тусгасан нь албан тушаалын чиг үүргийг оновчтой тодорхойлоогүй
- Сумдын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт дахь чиг үүргийг жишиг зааврыг баримтлан тусгасан боловч өдөр тутмын шинжтэй ажлуудыг чиг үүрэг болгон хэт жижиглэн задалсан, тухайн албан тушаалд хамаарах чиг үүргийг тусгаагүй нь албан тушаалын чиг үүргийг бүрэн, зөв тодорхойлоогүй

Иймд албан тушаалын тодорхойлолтод өдөр тутмын давтамжтай хэрэгжих ажлуудыг бус, тухайн албан тушаалын зорилго, үндсэн чиг үүрэг, хүлээх үр дүнг тусгах чиг үүргийг давхардалгүй, хэмжиж болохуйц, хэрэгжүүлэх түвшний бус удирдлага, зохион байгуулалтын түвшинд тодорхойлох, албан тушаалын тодорхойлолтыг батлагдсан загвар, аргачлалд нийцүүлэн дахин хянаж шинэчлэх шаардлагатай байна.

Аймаг, сумын төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг холбогдох хууль, журам, заавартай тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Аймгийн СТСХ-ийн Бүртгэл, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч албан тушаалын тодорхойлолтод "Санхүүгийн зохицуулах хорооны орон нутаг дахь төлөөлөгч"-ийн чиг үүргийг тусгасан атлаа

- тухайн чиг үүргийг хэрэгжүүлж байсантай холбогдуулан сар бүрийн нэмэгдлийг 20 хувиар тогтоон олгосон нь нэмэгдэл олгох хууль эрх зүйн үндэслэлтэй нийцээгүй
- 2026 онд бүртгэл, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн албан тушаалд албан тушаалын тодорхойлолтоор тавигдсан "Мэргэшил-Мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй байх" гэсэн тусгай шаардлагыг хангаагүй албан хаагчийг томилсон нь төрийн албанд томилгоо хийх хууль журмыг мөрдөөгүй

Эдгээр нь Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5¹, 7 дугаар зүйлийн 7.1.4², 50 дугаар зүйлийн 50.1³, 57 дугаар зүйлийн 57.2.2⁴, 57.12⁵, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6⁶, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 1.1⁷, 1.2⁸, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2⁹, 5 дугаар зүйлийн 5.1¹⁰, 5.1.10¹¹, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1¹² дэх заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Бүртгэл, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн албан тушаалд албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага, шалгуурыг хангасан төрийн жинхэнэ албан албан хаагчийг томилох, мөн албан тушаалын тодорхойлолтод тусгасан чиг үүргээ хэрэгжүүлж буй албан хаагчид хавсарсны нэмэгдэл 20 хувь олгосон зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аймаг, сумын СТСХ, Санхүүгийн албаны нийт 10 албан хаагчийг “Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагч, бүтэц, чиг үүргийн судалгаа”-д хамруулсан. Судалгаагаар “Таны албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг үү?” гэсэн асуултад 100 хувь нь “Бүрэн нийцдэг”, “Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүрэг хэрэгжүүлдэг үү?” гэсэн асуултад 100 хувь нь “Үгүй” гэж хариулсан байна.

¹ "албан тушаалын тодорхойлолт" гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг.

² Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах

³ Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ

⁴ Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс

⁵ Төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэмэгдэл хөлс олгоно

⁶ Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно

⁷ Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 57.2.2, 57.2.4, 57.8, 57.12-т заасны дагуу төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгохтой холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна

⁸ Энэ журмын 1-д заасан төрийн албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэмэгдэл хөлс олгоход энэ журмыг удирдлага болгоно

⁹ өрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтан Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сул орон тоог олон нийтэд мэдээлэх, төрийн жинхэнэ албан хаагч төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах үүднээс уг албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5-аас доошгүй хоногийн хугацаанд Зөвлөлийн цахим хуудас, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системээр мэдээнэ. Төрийн жинхэнэ албан хаагч тухайн албан тушаалын тусгай шаардлагыг хангаж буй тохиолдолд адил төрлийн албан тушаалын адил ангилалд шилжүүлэн ажиллуулахдаа тусгай шалгалтгүйгээр шууд томилно

¹⁰ Дараах болзлыг хангасан албан хаагч, иргэн шалгалтад бүртгүүлнэ

¹¹ зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх

¹² Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулахад тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд сонгон шалгаруулалт явуулахгүй

1.2.3. Төрийн сангийн цахим систем нь хэрэглэгчдийн үндсэн хэрэгцээг хангаж байгаа боловч мэдээллийн аюулгүй байдал, дотоод хяналт, техник технологийн найдвартай ажиллагаа болон системийн уялдаа холбоог холбогдох стандарт, шаардлагад нийцүүлэн сайжруулах шаардлагатай байна.

Төрийн сангийн цахим систем гэдэгт “Эрхийн бүртгэлийн сан систем” болон “Төрийн сангийн удирдлагын цахим систем”-ийг хамруулсан бөгөөд эдгээрт Сангийн сайдын 2024 оны 255 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн цахим системийн заавар”, 256 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар”-ыг мөрдөн ажиллаж байна.

ЗГСУМС болон төрийн сангийн цахим системийн нууц үгийг задруулахгүй байх үүргийг тухайн системийн хэрэглэгч хариуцдаг. Гэвч бодит нөхцөлд төрийн сангийн ажилтнууд эрхээ түр шилжүүлэхдээ холбогдох маягтаар баталгаажуулан шилжүүлдэг боловч төсөв захирагч, нягтлан бодогч нар гадаад томилолт болон бусад шалтгаанаар эзгүй байх үед нууц үгээ бусдад дамжуулах, эсхүл гадаадаас VPN ашиглан гүйлгээ хийх тохиолдол гарч байгаа нь мэдээллийн аюулгүй байдалд эрсдэл учруулж байна.

Аудитаар аймаг, сумын төрийн сангийн албан тушаалтнуудын ашиглаж буй компьютер, тоног төхөөрөмжийн найдвартай байдал болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг шалгахад албан ёсны үйлдлийн системгүй, вирусийн эсрэг программгүй, зөөврийн хадгалах төхөөрөмж залгах боломжтой, серверийн өрөөний нэвтрэх хаалганд хяналтын камергүй, сүлжээний тоног төхөөрөмжийн хайрцаг битүүмжлэлгүй зэрэг зөрчил илэрсэн. Энэ нь мэдээллийн аюулгүй байдлын биет хамгаалалт хангалтгүй байгааг харуулж байна. Иймээс ЗГСУМС болон төрийн сангийн цахим системд нэвтрэх, гүйлгээ хянах, баталгаажуулах эрх бүхий албан хаагчдын ашиглах техник хэрэгслийг албан ёсны үйлдлийн систем, программ хангамж, вирусийн хамгаалалтаар хангах, зөөврийн төхөөрөмжийн хэрэглээг хязгаарлах, серверийн өрөө болон сүлжээний тоног төхөөрөмжийн хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

Төрийн сангийн удирдлагын цахим систем, Төрийн албаны цалингийн нэгдсэн систем, Эрхийн бүртгэлийн системийн ашиглалт, хүртээмж, найдвартай байдал нь төрийн сангийн ажилтнууд болон гүйлгээ хийж буй байгууллагын удирдлага, нягтлан бодогчдын хэрэгцээ шаардлагад хэр нийцэж байгааг тодорхойлох зорилгоор судалгаа авсан. Судалгаанд төрийн сангийн гүйлгээг хянах, батлах эрхтэй аймгийн 3, сумын 5 нийт 8 албан хаагч, мөн гүйлгээ хийж буй байгууллагын төсөв захирагч, нягтлан бодогч нийт 56 албан хаагч хамрагдсан бөгөөд үр дүн нь дараах байдалтай байна.

Төрийн сангийн хэрэглэгч буюу хянах, батлах эрхтэй албан хаагчдаас авсан судалгаа:

1. Төрийн сангийн үйл ажиллагааг явуулахад цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ? Хэвийн хангаж байгаа-7, Бүрэн хангаж байгаа-1
2. Цахим систем таны хэрэгцээг хангаагүй бол юунаас үүдэж байгаа талаар товч бичнэ үү. Байхгүй-8
3. Төрийн сангийн ажлыг гүйцэтгэхэд цахим системээс гадна цаасан суурьтай баримт үйлддэг үү? Тийм-7, Үгүй-1
4. Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ? Интернетийн тасалдал-8
5. Төрийн сангийн үйл ажиллагааг цахим систем ашиглан орон зай үл хамааран гүйцэтгэх боломжтой юу? Тийм-8
6. Төрийн сангийн цахим системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзэж байна уу? Тийм-8
7. Төрийн сангийн цахим системийн ашиглалтын хүртээмж, найдвартай байдлыг сайжруулах талаар саналаа товч бичнэ үү. Саналгүй-8

Төрийн сангийн хэрэглэгч буюу төсөв захирагч, нягтлан бодогчдоос авсан судалгаа:

1. Төрийн сангийн цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ? Бүрэн-28, Хэвийн-28
2. Төрийн сангийн цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ? Программын тасалдал-22, Ямар нэг хүндрэл гардаггүй-20, Сургалт хангалтгүй, систем ойлгомжгүй-8, Тоног төхөөрөмж хангалтгүй, гар утаснаас хүснэгт харагддаггүй, Tender.gov.mn-ээс баримт хавсаргах боломжгүй-6

3. Төрийн сангийн цахим систем ашиглахад ойлгомжтой, хялбар байна уу? Тийм-52, Үгүй-4
4. Төрийн сангийн цахим системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзэж байна уу? Тийм-34, Үгүй-5, Мэдэхгүй-17
5. Системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой ажиллаж чадаж байна уу? Тийм-46, Үгүй-10
6. Системд үүссэн асуудлыг систем хариуцагч байгууллагын зүгээс бүрэн, шуурхай шийдвэрлэдэг үү? Тийм-40, Удаашралтай-13, Үгүй-3
7. Төрийн сангийн цахим системийн ашиглалт, хүртээмж, найдвартай байдал, бусад системтэй хэрхэн холбогддог, сайжруулах талаар санал байвал товч бичнэ үү. Программ хоорондын уялдааг сайжруулах /НББ-ийн программ, Шилэн данс, Татвар, Нийгмийн даатгалын системтэй уялдах байдлыг сайжруулах/, систем гацах асуудлыг шийдвэрлэх

Судалгааны үр дүнгээс харахад: Төрийн сангийн цахим систем нь хэрэглэгчдийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжиж байгаа боловч системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах шаардлага тулгарсан байна. Цаашид төрийн сангийн цахим системийн хэрэглэгчдэд систем ашиглалт болон мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах, ашиглаж буй тоног төхөөрөмжийн аюулгүй, найдвартай ажиллагааг хангах, сүлжээ болон серверийн биет хамгаалалтыг сайжруулах, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2

Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа боловч санхүүжилт, зарцуулалтын эрх олголт, төлбөр тооцоотой холбоотой нийтлэг зөрчлүүд давтагдсан байна.

2.1. Орон нутгийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу бүрэн олгоогүй, зарцуулалтын эрх олголт журмын шаардлагад нийцээгүй байна.

2.1.1. Орон нутгийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн олгож чадаагүй байна.

Төсвийн санхүүжилтийн эрх олголт Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-аар зохицуулагдсан байна.

Хүснэгт №02 Аймгийн хэмжээнд 2023-2025 онд олгосон санхүүжилт /сая төгрөгөөр/

Аймаг, сумын нэр	Төсвийн сар, улирлын хуваарь	Олгосон санхүүжилт	Зөрүү
Аймаг	15,748.4	15,660.1	88.3
Сүмбэр	7,390.6	7,315.8	74.8
Шивээговь	3,716.5	3,461.4	255.1
Баянтал	1,837.9	1,837.0	0.9
Нийт	28,693.4	28,274.3	419.1

2023 онд нийт 28,274.3 сая төгрөгийн санхүүжилтийн эрх олгосон бөгөөд аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт 204.4 сая, сумдын ХХС-ийн санхүүжилт 36.9 сая, орон нутгийн орлого бүрдээгүйн улмаас Шивээговь сумын ЗДТГ 24.7 сая төгрөг, аймгийн төсөвт төвлөрүүлэх санхүүгийн дэмжлэг 177.8 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжсэн байна.

Аймаг, сумын нэр	Төсвийн сар, улирлын хуваарь	Олгосон санхүүжилт	Зөрүү
Аймаг	23,648.7	23,539.0	109.7
Сүмбэр	12,979.5	12,583.0	396.5
Шивээговь	4,934.1	4,627.1	307.0
Баянтал	2,936.3	2,934.2	2.1
Нийт	44,498.6	43,683.3	815.3

2024 онд нийт 43,683.3 сая төгрөгийн санхүүжилтийн эрх олгосон бөгөөд аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт 363.5 сая, сумдын ХХС-ийн санхүүжилт 275.2 сая, орон нутгийн орлого бүрдээгүйн улмаас Шивээговь сумын ИТХ, ЗДТГ нийт 176.6 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн байна.

Аймаг, сумын нэр	Төсвийн сар, улирлын хуваарь	Олгосон санхүүжилт	Зөрүү
Аймаг	27,664.7	27,537.9	126.8
Сүмбэр	16,977.8	16,265.1	712.7
Шивээговь	5,432.4	4,921.9	510.5
Баянтал	2,646.9	2,584.7	62.2
Нийт	52,721.8	51,309.6	1,412.2

2025 онд нийт 51,309.6 сая төгрөгийн санхүүжилтийн эрх олгосон бөгөөд аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт 570.5 сая, сумдын ХХС-ийн санхүүжилт 166.0 сая, орон нутгийн орлого бүрдээгүйн улмаас Сүмбэр сумын аймагт төвлөрүүлэх санхүүгийн дэмжлэг 560.4 сая төгрөг, Шивээговь сумын ИТХ, ЗДТГ 176.6 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжсэн байн

2023-2025 онд аймгийн СТСХ болон сумдын Санхүүгийн алба нь төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрх нээсэн байдлыг төсвийн байгууллагуудын дансны хуулга, СЭБ маягттай тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Аймгийн СТСХ нь 6 байгууллагад 110.2 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн сар, улирлын хуваарийг баримтлалгүйгээр тухайн сард илүү олгож дараагийн сард нь залруулсан, мөн 2025 онд "Орон нутгийн төсвөөс хуваарилах санхүүжилтийн эрх олгох жагсаалт СЭБ" маягтад олгосон санхүүжилтийг 2 байгууллагад 2.7 сая төгрөгөөр илүү, 3 байгууллагад 7.7 сая төгрөгөөр дутуу баталгаажуулсан
- Сүмбэр сумын Санхүүгийн алба нь 2023, 2025 онд 1 байгууллагад 19.3 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн сар, улирлын хуваарийг баримтлалгүйгээр тухайн сард илүү олгож дараагийн сард нь залруулсан
- Шивээговь сумын Санхүүгийн алба нь батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг мөрдөөгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс 2025 онд 1 байгууллагад холбогдох хуваариас хэтрүүлэн 2.1 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 24 дүгээр хавсралтаар батлагдсан "Орон нутгийн төсвөөс хуваарилах санхүүжилтийн эрх олгох жагсаалт СЭБ" маягтын дагуу 2023 оны 1-11 дүгээр сарын санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаж баталгаажуулаагүй, мөн 2024–2025 онуудад тус СЭБ маягтаар санхүүжилтийг огт хянуулж, баталгаажуулалт хийгээгүй
- Баянтал сумын Санхүүгийн алба нь батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг мөрдөөгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс 2024 онд 2 байгууллагад 15.9 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн сар, улирлын хуваарийг баримтлаагүйгээс тухайн сард олгоогүй, дараагийн сард нөхөж олгосон
- Сүмбэр, Шивээговь сумын Санхүүгийн алба нь 2023-2025 онд орон нутгийн санхүүжилтээс шалтгаалан 738.2 сая төгрөгийн аймагт төвлөрүүлэх санхүүгийн дэмжлэгийг дутуу төвлөрүүлсэн
- Аймгийн хэмжээнд 2023-2025 онд орон нутгийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан 13 байгууллагад 349.8 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн сар, улирлын хуваарийг баримтлалгүйгээр тухайн сард нь дутуу олгосон бөгөөд дараа сард нь нөхөн санхүүжүүлсэн
- Аймгийн хэмжээнд жилийн эцсийн гүйлгээ хаагдаж үлдэгдэл төвлөрүүлсний дараа ЗГ-аас үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гарсны улмаас 295.4 сая төгрөгийн санхүүжилт нэмж олгосон

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон сумдын Санхүүгийн алба нь төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрх нээж, санхүүжилт олгож байгаа боловч нийтлэг зөрчил давтагдан илэрч байна. Үүнд: санхүүжилтийг батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу бүрэн олгоогүй, орон нутгийн орлого тасарснаас шалтгаалан санхүүжилт дутуу олгосон, "СЭБ" маягтаар санхүүжилтийг бүрэн баталгаажуулаагүй, мөн санхүүгийн дэмжлэгийг хугацаанд нь төвлөрүүлээгүй зэрэг зөрчил хамаарч байна. Түүнчлэн жилийн эцсийн гүйлгээ хаасны дараа ЗГ-ын шийдвэрээр дахин санхүүжилт олгосон нь улсын хэмжээнд Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг зөрчсөнийг харуулж байна. Иймээс төсвийн зарцуулалтын эрх олголт нь ерөнхийдөө хэрэгжиж байгаа хэдий ч төсвийн хуваарь, баталгаажуулалт, баримтжуулалт, орлогын төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн СТСХ болон сумдын Санхүүгийн албанд төсвийн сар улирлын хуваарийн дагуу санхүүжилт олгох, эрх нээх, олгосон төсвийн санхүүжилтийн дагуу "Орон нутгийн төсвөөс хуваарилах санхүүжилтийн эрх олгох жагсаалт СЭБ" маягтыг үнэн зөв хөтөлж, сар бүр баталгаажуулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.1.2 Барьцаа хөрөнгө болон нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг журамд нийцүүлэн олгоогүй байна.

Төсвийн зарцуулалтын эрх олголтын талаар Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.8-д "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох журам", 2.9-д "Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх олгох журам", 2.10-д "Захиалагчийн хяналтын зардлын эрх олгох

журам”, 2.11-д “Норм, нормативын зардлын эрх олгох журам”, 2.12-д “Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох журам”-д тус тус заасан байна.

1. Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх олгох журам

2023-2025 онд аймаг, сумын хэмжээнд нийт 852.4 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн зардлын эрх олгосон байна.

Барьцаа хөрөнгийн дансны зардлын эрх нээлгэх үйл ажиллагаа журамд заасан шаардлагад нийцсэн эсэхийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Сүмбэр сумын Санхүүгийн алба нь 2023-2025 онд нийт 171.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн зардлын эрх олгосон хэдий ч захиалагч нь эрх нээлгэх хүсэлтээ Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 27 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу баталгаажуулаагүй, мөн төрийн сангаас уг хүсэлтийг маягтын дагуу хянаж баталгаажуулаагүй
- Шивээговь сумын Санхүүгийн алба 2023 онд барьцаа хөрөнгийн зардлын эрх олгоогүй, 2024-2025 онд нийт 106.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн зардлын эрх олгосон хэдий ч захиалагч нь эрх нээлгэх хүсэлтээ Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 27 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу баталгаажуулаагүй, мөн гэрээ, дүгнэлтийг хавсаргаагүй байхад төрийн сангаас зарцуулалтын эрх нээсэн, хяналт хэрэгжүүлээгүй
- Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу хяналт тавьж ажиллаагүйгээс ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн ‘Баяр наадмын талбайг шинээр барих’, ‘Баяр наадмын талбайг өргөтгөх нэмэлт ажил’-ын захиалагчийн хяналтын зардлыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй байтал 2,965.4 мянган төгрөгийн барьцаа дансны зарлагын эрхийг Баянтал сумын Санхүүгийн алба хянан баталгаажуулалт хийхгүйгээр шууд нээж, зарцуулах эрх олгосон

Эдгээр зөрчил нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.9 дүгээр зүйлийн 2.9.1¹³, 2.9.2¹⁴-д заасантай нийцээгүй байна.

Иймд сумдын Санхүүгийн албанд хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны зарцуулалтын эрхийг нээхдээ захиалагчийн шийдвэр, холбогдох хууль, гэрээний заалт болон Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан шаардлага, анхан шатны баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан эсэхэд хяналт тавьж, зөвхөн шаардлага хангасан тохиолдолд санхүүжилтийн эрхийг олгож байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. Захиалагчийн хяналтын зардлын эрх олгох журам

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналт хийхтэй холбоотой зардлыг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлэлгүй аймгийн ЗДТГ болон ГХБХБГ нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

3. Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох журам

2023-2025 онд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 130 байгууллагад нийт 7,051.9 сая төгрөгийн нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгосон байна.

Хүснэгт №03 2023-2025 онд олгосон нэмэлт төсвийн зарцуулалтын судалгаа

/сая төгрөгөөр/

Аймаг, сумын нэр	Хүсэлт өгсөн байгууллагын тоо	Хянаж эрх олгосон мөнгөн дүн	Үүнээс:		
			Зарцуулалтын эрхийг ажлын 3	Шийдвэр, гэрээ, тушаал бүрдсэн, баримт	Баримт материал үдэж архивлаагүй

¹³ 2.9.1.Төсвийн захирагч буюу захиалагч нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх нээлгэх хүсэлтийг энэ журмын 27 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан гэрээ, комиссын дүгнэлт, ашиглагч байгууллагын тодорхойлолтын хамт харьяа төрийн санд хүргүүлнэ

¹⁴ 2.9.2.Энэ журмын 2.9.1-д заасан төрийн сан нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрхийг төсвийн захирагч буюу захиалагчийн шийдвэр, хууль болон гэрээнд заасан холбогдох заалтыг үндэслэн олгоно

	/давхардсан тоогоор/		өдрийн дотор шийдвэрлээгүй	бичиг хавсаргаагүй	
Аймгийн СТСХ	86	6,365.3	63 байгууллага-1,523.9 сая /1-29 хоног/	46 байгууллага-1,994.6 сая	8 байгууллага-191.7 сая
Сүмбэр	18	377.0	14 байгууллага-209.0 сая/5-15 хоног/	4 байгууллага-17.0 сая	-
Шивээговь	15	185.9	3 байгууллага-22.3 сая /4-12 хоног/	7 байгууллага-77.9 сая	-
Баянтал	11	123.7	3 байгууллага-8.1 сая /7-22 хоног /	9 байгууллага-95.2	-
Нийт	130	7,051.9			

Эх сурвалж: Аудиторын тулган баталгаажуулалт

Хүснэгтээс харахад аймгийн СТСХ болон сумдын Санхүүгийн албанд нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олголттой холбоотой нийтлэг зөрчил илэрсэн байна. Тухайлбал, 83 байгууллагын 1,763.3 сая төгрөгийн зарцуулалтын эрхийг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй, 66 байгууллагын 2,184.7 сая төгрөгийн зарцуулалтын эрх олгохдоо холбогдох баримт бичгийг бүрэн хавсаргаагүй, мөн 8 байгууллагын 191.7 сая төгрөгийн баримт материалыг үдэж, архивлаагүй байна. Эдгээр нь 2018 онд гүйцэтгэсэн “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” сэдэвт нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

Эдгээр зөрчлүүд нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.12 дугаар зүйлийн 2.12.2¹⁵, 2.12.2.1¹⁶, 2.12.2.2¹⁷, 2.12.2.3¹⁸, 2.12.3¹⁹-д заасантай нийцээгүй байна.

Иймд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, цаашид журамд заасан шаардлага хангасан төсвийн байгууллагын хүсэлтэд нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох, эрхийг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэх тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Төсвийн зарцуулалтын эрх олголттой холбоотой нийтлэг зөрчлүүд илэрч байгаа нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй
- Хариуцсан албан хаагчдын ажлын уялдаа холбоо, хариуцлага хангалтгүй
- Зарцуулалтын эрх олгох үйл ажиллагааны журмыг мөрдөөгүй
- Баримт материалыг бүрдүүлэх, архивлах үйл ажиллагаа стандартын дагуу хийгдээгүй
- Хүний нөөцийн тогтворгүй байдал сөргөөр нөлөөлсөн
- Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн нотлох баримтын бүрдэл дутуу хүсэлтэд хяналт хэрэгжүүлээгүй

Иймээс дотоод хяналтыг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх, баримт бүрдүүлэлт болон архивын стандартыг мөрдүүлэх, албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.2. Аймаг, сумдын төрийн сан төлбөр тооцооны хяналтад санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлтийг харилцан адилгүй ойлгож, ялгаатай байдлаар хэрэгжүүлсэн байна.

2.2.1. Сүмбэр, Шивээговь сумын Санхүүгийн алба боловсролын салбарын байгууллагуудаас дансны үлдэгдлийн баталгаа гаргуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

¹⁵ Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг дараах баримт бичгийн хамт цахимаар, эсхүл албан бичгээр харьяалагдах төрийн санд хүргүүлнэ

¹⁶ Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу тухайн эх үүсвэрийг нотлох холбогдох тушаал, шийдвэр, гэрээ

¹⁷ нэмэлт төсвийг зарцуулах тухай төсвийн захирагчийн шийдвэр болон бусад холбогдох шийдвэр

¹⁸ энэ журмын 32 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулсан нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлт

¹⁹ 2.12.3.Төрийн сан нь энэ журмын 2.12.2-г заасан шаардлагыг хангасан төсвийн байгууллагын хүсэлтийг хянаж, ажлын 3 өдрийн дотор зарцуулах эрхийг олгоно

2025 оны байдлаар төрийн санд нийт 341 данс байршиж байгаагаас урсгал үйл ажиллагааны данс 97, нэмэлт төсвийн данс 46, ахмадын сангийн данс 51, хөрөнгө оруулалтын болон барьцаа хөрөнгийн данс 20, тусгай сангийн данс 14, татварын болон татварын бус орлогын данс 108, ерөнхий данс 5 байна.

2023-2025 онд аймгийн CTCX-ээс нийт 41 байгууллагын 129 дансны үлдэгдлийн баталгааг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

2023-2025 онд сумдын Санхүүгийн алба хагас болон бүтэн жилийн байдлаар дансны үлдэгдлийн баталгааг гаргуулж, баталгаажуулсан эсэхийг тулган шалгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. 2023 онд Сүмбэр сумын Санхүүгийн алба нь 1 байгууллагын дансны үлдэгдлийг 1,404.1 мянган төгрөгөөр илүү баталгаажуулсан, 6 байгууллага үлдэгдлийн баталгаа гаргаагүй, төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулаагүй. Мөн 2024-2025 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд /ЕБС, СӨБ/ дансны үлдэгдлийн баталгаа гаргаагүй бөгөөд төрийн сангаас хянаж баталгаажуулаагүй
2. 2023 онд Шивээговь сумын Санхүүгийн алба нь 2023 онд төсөвт байгууллагуудаас хүлээн авсан дансны үлдэгдлийн баталгааг үдэж архивлаагүй, мөн 2024-2025 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд /ЕБС, СӨБ/ дансны үлдэгдлийн баталгаа гаргаагүй бөгөөд төрийн сангаас хянаж баталгаажуулаагүй

Эдгээр зөрчил нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4 дүгээр зүйлийн 3.4.24²⁰ дэх заалттай нийцээгүй байна.

Иймд Сүмбэр, Шивээговь сумын Санхүүгийн албанд харьяа төсөвт байгууллагуудын дансны үлдэгдлийн баталгааг хагас бүтэн жилээр гаргуулан авч, тооцоо нийлж баталгаажуулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.2.2. Төрийн сан, төсвийн байгууллагууд төлбөр тооцоо, зарлагын гүйлгээ хийхдээ үндэслэх баримт бичиг, зориулалт, ангиллын дагуу гүйцэтгэсэн байна.

ТСУЦС-д 2023 оны 02 дугаар сараас эхлэн шилжсэн бөгөөд 2023-2025 онд аймгийн хэмжээнд нийт 349,386.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Хүснэгт №04 2023-2025 онд аймгийн хэмжээнд хийгдсэн гүйлгээний тоо, зарлагын гүйлгээний мөнгөн дүн

/сая төгрөгөөр/

Аймаг, сумын нэр	2023		2024		2025		Тайлбар
	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	
Аймгийн CTCX	21011	58,583.3	27000	84,055.3	24131	85,782.5	
Сүмбэр	6068	16,640.5	6987	29,543.8	7132	33,275.7	
Шивээговь	3536	6,185.2	3867	9,799.2	3891	11,437.4	
Баянтал	2301	2,799.3	2764	5,598.6	2678	5,685.9	
Нийт	32916	84,208.3	40618	128,996.9	37832	136,181.5	

Эх сурвалж: УАГ-аас ирүүлсэн гүйлгээний мэдээлэл

2023-2025 онд зарлагын гүйлгээний тоо тасралтгүй өссөн нь орон нутгийн төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна. Тухайлбал, нийт зарлагын гүйлгээний мөнгөн дүн 2023 онд 84.2 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 129.0 тэрбум, 2025 онд 136.2 тэрбум төгрөгт хүрч өссөн байна.

Хүснэгт №05 2023-2025 онд аймгийн хэмжээнд хийгдсэн гүйлгээнээс буцаасан шалтгааныг задалж харуулбал:

²⁰ 3.4.24.Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан тушаалтан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг мөн журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үйлдэн хагас жил тутам харьяа төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулна

/сая төгрөгөөр/

Буцаасан гүйлгээ /2023-2025 он/

Аймаг, сумын нэр	Нийт	Төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болсон	Төлбөрийн хүсэлтийн мөнгөн дүн, үндэслэх анхан шатны баримтын дүнгээс их	ТХТХ зөрчсөн	Төрийн сан, төсвийн байгууллагын харилцааг зохицуулсан журмыг зөрчсөн	Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу	Хяналтын хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл болоогүй.	Бусад
Аймаг	17,555.0	314.4	523.7	78.9	60.7	2,603.2	13,930.1	44.0
Сүмбэр	8,283.9	435.8	533.9	52.3	26.1	423.1	6,735.9	76.8
Шивээговь	1,096.0	125.6	25.0	-	0.1	194.0	726.2	25.1
Баянтал	624.8	77.4	8.6	-	-	68.8	465.2	4.8
Нийт дүн	27,559.7	953.2	1,091.2	131.2	86.9	3,289.1	21,857.4	150.7

Эх сурвалж: УАГ-аас ирүүлсэн гүйлгээний мэдээлэл

2023-2025 онд хийгдсэн нийт гүйлгээнээс 7.9% буюу 27,559.7 сая төгрөгийн гүйлгээг буцаасан байна.

Буцаасан шалтгааныг хүснэгтээс харахад:

- Хяналтын хуудасны хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл болоогүй-79.3%,
- Хөтөлбөр, зориулалт эдийн засгийн ангилал зөрчсөн-11.9%,
- Төлбөрийн хүсэлтийн мөнгөн дүн анхан шатны баримтын дүнгээс их-4.0%,
- Төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болсон-3.5%
- ТХТХ зөрчсөн-0.4%
- Төрийн сан, төсвийн байгууллагын харилцааг зохицуулсан журмыг зөрчсөн-0.3%
- Бусад-0.6%

Буцаасан гүйлгээний 79.3 хувь нь “Хяналтын хуудасны хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, иж бүрдэл бүрдээгүй” гэсэн шалтгаантай байгаа нь төсөвт байгууллагын нягтлан бодогчдын хууль, журмын мэдлэг, ур чадвартай холбоотой байна. Харин Шивээговь, Баянтал суманд “ТХТХ зөрчсөн” шалтгаанаар гүйлгээ буцаагаагүй байгаа нь тухайн сумдад зөвхөн ТХТХ-ийн хэрэгжилт бус, гүйлгээнд тавих хяналт сул, эрсдэлтэй байгааг харуулж байна.

Нийт гүйлгээний 3.5 хувь буюу 953.2 сая төгрөгийн гүйлгээ “Төрийн сангийн ажилтан батлахгүй 72 цаг болсон” шалтгаанаар буцаагдсан байна. Хянаагүй буцаасан шалтгааныг тодруулахад төсөвт байгууллагууд долоо хоногийн 4 дэх өдөр гүйлгээ илгээж, дараагийн өдөр бүх нийтийн амралт таарсан, эсхүл сарын сүүлийн өдөр амралтын өдөртэй давхцсан зэрэг нөхцөл байдал нөлөөлсөн талаар тайлбар өгсөн байна.

2023-2025 онд аймгийн хэмжээнд хийгдсэн нийт гүйлгээнээс давхардсан тоогоор 136 байгууллагын 7,069.9 сая төгрөгийн 674 гүйлгээг түүвэрлэж, үндэслэх баримт бичиг, мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, зориулалт, ангиллын дагуу гүйцэтгэсэн эсэхийг шалгах хуудсаар тулган баталгаажуулсан. Тухайлбал:

- 2023 оны 1, 2 дугаар сард төсөвт байгууллагууд цалингийн гүйлгээ хийхдээ зөвхөн цалингийн тооцооны хүснэгт, цалин олгох хүснэгт, цалингийн задаргааг хавсаргасан /Систем дөнгөж хэрэгжиж эхэлж байсан учраас жигдрээгүй байсан /
- “210801-Мэргэжлийн үйлчилгээний төлбөр” эдийн засгийн ангиллаас /гарын авлага, эмхэтгэл, ажлын хөлс, шатахуун, хогны төлбөр, сэлбэг хэрэгсэл, цалин, контент, шатахуун, хоол, цай/ гүйлгээнүүд хийгддэг учраас бодит байдалд эдийн засгийн ангиллаар хянах боломжгүй
- “210901-Бараа үйлчилгээний бусад зардал” эдийн засгийн ангиллаас /Хоол цай, шатахуун, засварын материал, контент, компьютер техник хэрэгсэл, бичиг хэрэг, ажлын хөлс/ хөтөлбөр, зориулалт эдийн засгийн ангиллаар хянах боломжгүй
- “210502-Хоол хүнс” эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийхэд анхан шатны баримтууд харилцан адилгүй хавсаргасан байна. Тухайлбал: аймгийн төсөвт байгууллагуудад

нэхэмжлэх, зарлагын баримт хавсаргаж байгаа бол Сүмбэр сумын төсөвт байгууллагууд нэхэмжлэх, тендерийн баримт бичиг, гэрээ, Шивээговь, Баянтал сумын төсөвт байгууллагууд нэхэмжлэх, шинжилгээний бичиг, гэрээ

- “210601-Багаж техник хэрэгсэл” эдийн засгийн гүйлгээ хийхэд анхан шатны баримтууд харилцан адилгүй хавсаргасан байна. Тухайлбал: Зарим төсөвт байгууллага зөвхөн нэхэмжлэх хавсаргасан байхад зарим нь нэхэмжлэх, гэрээ, тушаал, зарлагын баримт г.м

Эндээс үзэхэд аймаг, сумын төрийн сан төлбөрийн гүйлгээг хянахдаа анхан шатны баримтын бүрдлийг харилцан адилгүй ойлгож, ялгаатай байдлаар хянаж баталгаажуулсан байна. Түүнчлэн 210801, 210901 зэрэг эдийн засгийн ангиллаар гүйлгээ хийх үед хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллаар нарийвчлан хянахад хүндрэл үүсэж байна.

Иймд санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлд тавигдах шаардлагыг нэг ойлголттой болгож, аймаг, сумдын хэмжээнд нэгдсэн аргачлалыг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд Төрийн сангийн үйл ажиллагааны журамд энэ бүрдлийн шаардлагыг илүү тодорхой, нарийвчлан тусгах нэн шаардлагатай байна.

Түүвэрлэсэн гүйлгээнээс нийт 30 гүйлгээ буюу 187.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээг сар бүрийн эцсийн ажлын өдрийн 14:00 цагаас хойш хийж, хянаж баталгаажуулсан нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.5 дугаар зүйлийн 3.5.8²¹-д заасантай нийцээгүй байна.

Иймд илэрсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, цаашид сар бүрийн эцсийн ажлын 14:00 цагаас хойш зарлагын гүйлгээг хаах, гүйлгээ хийгдсэн тохиолдолд буцаах, хянаж баталгаажуулахгүй байх талаар аймаг, сумдын Санхүүгийн албанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Төрийн сангийн төлбөр тооцооны системд зарлагын гүйлгээ хаагдсан тохиолдолд системийн тохиргоонд тухайн гүйлгээг илгээх, хянах, баталгаажуулах эрхийг хаах автомат хязгаарлалт нэвтрүүлэх шаардлагатай байна.

2.2.3. Төсвийн байгууллагууд тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулж байгаа боловч журамд заасан хугацааг хэтрүүлсэн байна.

2023-2025 онд аймаг, сумын хэмжээнд орлого бууруулах нийт 30,212.9 сая төгрөгийн 2654 гүйлгээ хийгдсэн байна. Орлого бууруулах гүйлгээний утгыг ангилан аймаг, сумдаар нь харуулбал:

Хүснэгт №06 Орлого бууруулах гүйлгээний ангилал

№	Ангиллын нэр	Код	Тоо	Мөнгөн дүн
1	Даатгалын төлбөр	300002	129	95.0
2	Барьцаа хөрөнгө	300003	30	420.3
3	Тендерийн орлого	300004	9	0.6
4	Ялтны хөлс	300009	518	184.9
5	Үлдэгдэл шилжүүлэх	300006	17	130.1
6	Орлого төвлөрүүлэлт	300011	183	24,149.0
7	НДЗ болон авлагад тооцох	300012	4	81.4
8	Тушаалаар олгосон дүн	300014	5	37.9
9	Нэр данс зөрүү	300015	1063	4,213.8
			1958	29,350.9
1	Даатгалын төлбөр	300002	154	47.3
2	Барьцаа хөрөнгө	300003	2	12.9
3	Тендерийн орлого	300004	6	0.4
4	Нэр данс зөрүү	300015	300	616.5
			462	677.1

²¹ 3.5.8.Төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдөр 14 цагт зарлагын гүйлгээг хаана

1	Шивээговь сумын Санхүүгийн алба	Даатгалын төлбөр	300002	105	32.9
2		Тендерийн орлого	300004	3	0.3
3		Нэр данс зөрүү	300015	75	48.3
				183	81.5
1	Баянтал сумын Санхүүгийн алба	Даатгалын төлбөр	300002	13	3.9
2		Нэр данс зөрүү	300015	38	99.5
				51	103.4
Нийт				2654	30,212.9

Хүснэгтээс харахад нийт орлого бууруулах гүйлгээний 79.9 хувь нь орлого төвлөрүүлэлттэй, 16.5 хувь нь нэр, дансны зөрүүтэй холбоотой байна.

Аудитаар 32 байгууллагын 136 гүйлгээг түүвэрлэн шалгахад дараах нөхцөл байдал тогтоогдсон.

Хүснэгт №07 Орлого бууруулсан гүйлгээний түүврийн жагсаалт

Аймаг, сумдын нэр	Байгууллагын тоо	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Нотлох баримт, хуулга хавсаргасан эсэх	Ажлын 3 өдрийн дотор хүсэлт гаргасан эсэх	Тайлбар
Аймаг	15	61	44.1	Тийм	3-150	61-хугацаа хэтэрсэн
Сүмбэр	7	47	29.6	Тийм	3-90	46-хугацаа хэтэрсэн
Шивээговь	6	20	11.8	Тийм	3-62	19-хугацаа хэтэрсэн
Баянтал	4	8	1.3	Тийм	3-78	8-хугацаа хэтэрсэн
Нийт	32	136	86.8			

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

Хүснэгтээс харахад түүвэрлэн шалгасан 32 байгууллагын 136 орлого бууруулсан гүйлгээ бүгд орлогын хуулгаар баталгаажсан боловч 134 гүйлгээг хуульд заасан ажлын 3 өдрийн дотор бус, 3-150 хоногоор хэтрүүлэн шийдвэрлэсэн байна.

Энэ нь төсвийн байгууллагын нягтлан бодогчдын Төрийн сангийн үйл ажиллагааны журмын талаарх мэдлэг хангалтгүй, орлогын хуулгыг өдөр тутам тогтмол хянадаггүй, мөн аймаг, сумдын төрийн сангаас хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

2.2.4. Аймгийн СТСХ, сумдын Санхүүгийн алба нь төсвийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох тодруулгыг хуулийн хугацаанд тайлагнасан байна.

2023-2025 онд аймгийн СТСХ нь Төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацаанд нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, сумдын Санхүүгийн алба нь сумын нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаж, аймгийн ТАГ-т хүргүүлж, аудитын дүгнэлтээ авсан байна.

2.3. Аймгийн СТСХ, сумдын санхүүгийн албанд төлөвлөгөөт хяналтууд хийгдэж байгаа боловч өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, ижил төрлийн зөрчил давтагдсан нь дотоод хяналт үр нөлөөгүй байгааг илтгэж байна.

2.3.1. Сумдын Санхүүгийн албанд хийгдсэн төлөвлөгөөт хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

Сангийн сайдын 2024 оны 65 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “Төлөвлөгөөт хяналт”, 4.1.3-т “Төлөвлөгөөт бус хяналт”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9.3.1-д “Төлөвлөгөөт хяналт”, 3.9.3.2-д “Төлөвлөгөөт бус хяналт” хэрэгжүүлэх талаар тус тус заасан байна.

- 1. Төлөвлөгөөт хяналт:** Аймгийн Засаг даргын 2023 А/84, 2024 оны А/103, 2025 оны А/120 дугаар захирамжаар батлагдсан төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт хяналтыг хэрэгжүүлж 2023 онд 8 эрсдэл, 31 зөвлөмж, 2024 онд 8 эрсдэл, 27 зөвлөмж, 2025 онд 16 эрсдэл 13 зөвлөмжийг хүргүүлж, тайлант онуудад биелэлтийг тооцсон байна. Дотоод хяналтаар илэрсэн нийтлэг зөрчлүүд нь төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг баталгаажуулаагүй, гарын үсгийн маягтын бүрдүүлэлт дутуу, авлага, өглөгийн мэдээний насжилтыг зөрүүтэй тайлагнасан, ТСУМС-д анхан шатны баримт дутуу гүйлгээг баталгаажуулсан зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Хүснэгт №08 2023-2025 онд сумдын Санхүүгийн албанд дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмж

Огноо	Сүмбэр сум	Шивээговь сум	Баянтал сум
2023 он	12	10	9
2024 он	9	11	7
2025 он	4	5	4
Нийт дүн	24	26	20

Хүснэгтээс харахад Сүмбэр суманд 24, Шивээговь суманд 26, Баянтал суманд 20 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд сумдын Санхүүгийн алба зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээллийг хугацаанд нь ирүүлсэн байна.

Хэдийгээр сумдын Санхүүгийн албанд төлөвлөгөөт хяналтыг журмын дагуу хийж байгаа боловч аудитаар дээр дурдсан нийтлэг зөрчлүүд дахин илэрсэн нь дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байгааг харуулж байна.

Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдал бүрээр шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавих зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- 2. Төлөвлөгөөт бус хяналт:** 2023-2025 онд аймгийн төрийн сан нь төлөвлөгөөт бус хяналт хийгээгүй байна.

Сангийн сайдын 2025 оны 56 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөө, ТНБД-ын А/101 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Сангийн яамны ажлын хэсэг 2025 онд Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын СТХС-ийн үйл ажиллагаа, хууль, журам, зааврын хэрэгжилтийн хүрээнд дотоод хяналтыг гүйцэтгэсэн байна. Аймгийн СТХС-ийн 2024, 2025 оны баримтуудыг түүвэрлэн дотоод хяналтаар хууль тогтоомжийг баримталж ажиллаж буй эсэх, болзошгүй эрсдлийн үнэлгээ, үндсэн үйл ажиллагааг сайжруулах гэсэн 3 чиглэлээр 23 эрсдэлийг үнэлж, дараах 5 зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн зарцуулах эрхийг олгохдоо Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолыг баримталж ажиллах
2. Нягтлан бодогчийн зөвшилцсөн бичиг авсны үндсэн дээр тухай нягтлан бодогчийг томилох тушаал гаргаж байхыг төсвийн байгууллагуудад мэдэгдэж, цаашид хууль, журмын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлсний дараа гүйлгээ хийх эрхийг баталгаажуулан ажиллах
3. Дотоод эх үүсвэрээс олгосон болон бусад эх үүсвэрээс авч дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор төлөвлөхгүй байх
4. Үндэслэх баримт бичгийн бүрдүүлбэрт анхаарч, худалдан авах ажиллагаа зохион байгуулсан баримт бичгийн мэдээллийг үндэслэх баримт бичиг хэсэгт цахимаар хавсаргах
5. Баяр наадам болон тэмцээн, уралдааны зардлыг холбоодын дансаар дамжуулан олгосон байна. Уг зардалд шагналын зардал багтах боловч, зарцуулалтын тайлан бүрэн гүйцэд бүрдүүлээгүй байна. Иймд зориулалтын бус зарцуулалт гарах эрсдэл үүсэж болзошгүй тул төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүйн актыг мөрдлөг болгон ажиллах

Дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Сангийн яамны төрийн сангийн газарт 2025 оны 12-р сард хүргүүлсэн байна.

2.3.2. Жил бүр төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийн үнэлгээг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2024 оны 65 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Өдөр тутмын хяналт”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9.3.3-д “Өдөр тутмын” хяналт хэрэгжүүлэх талаар тус тус заасан байна.

Өдөр тутмын хяналт: 2023-2025 онд аймгийн СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн тогтвортой ажилласан бөгөөд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж ажилласан талаар дотоод хяналтын тайланд тусгагдаагүй байна.

Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын Санхүүгийн алба нь жил бүрийн эхэнд төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг гаргаж үнэлэн, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Аймгийн СТСХ нь сумдын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтын тайлан болон эрсдэлийн үнэлгээг нэгтгэн Сангийн яамны төрийн сангийн газарт 2025.02.03-ны өдрийн Б/116, 2026.01.12-ны өдрийн А/56 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

2.3.3 Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт 89.6%-тай байна.

2018 онд УАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” сэдэвт нийцлийн аудит хийж, 3,786.3 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 10.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Мөн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, холбогдох журам, зааврыг мөрдөөгүй аймгийн ерөнхий санхүүч, төрийн сангийн ахлах мэргэжилтэн, төлбөр тооцооны мэргэжилтэн, төсөв, бүртгэлийн мэргэжилтэн, сумдын Санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдэд хариуцлага тооцуулах албан шаардлага, түүнчлэн зөрчил дутагдлыг арилгуулж, давтан гаргуулахгүй байх 41 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг хянаж үзэхэд дундаж хэрэгжилт 89.6 хувьтай байна.

1. 10.8 сая төгрөгийн төлбөрийн акт 100% хэрэгжсэн
2. Аймгийн ЗДТГ-ын даргад өгсөн 3 зөвлөмж 100%, аймгийн СТСХ-ийн даргад өгсөн 9 зөвлөмжөөс 7 зөвлөмж бүрэн хэрэгжсэн буюу 77.8%
3. Сумдын ЗДТГ-ын дарга нарт өгсөн 4 зөвлөмж 100%, Сумдын Санхүүгийн албаны дарга нарт өгсөн 11 зөвлөмжөөс хэрэгжилт 81.8%
4. Аймгийн ерөнхий санхүүч болон мэргэжилтнүүдэд 9 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 77.8%
5. Сумдын төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдэд өгсөн 5 зөвлөмжөөс 100%

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжөөс хэрэгжээгүй, зөрчил давтагдсан дараах асуудлууд байна.

1. Нэмэлт дансны санхүүжилтийн эрх нээлгэх болон төсөв захирагчийн төсөвт зохицуулалт хийлгэхээр ирүүлсэн байгууллагуудын албан бичгийг бүртгэлжүүлж, холбогдох баримт бичгийн бүрдлийг хянах, хүсэлтийг холбогдох хууль журамд нийцүүлэн шийдвэрлэх /Аймгийн СТСХ, сумдын Санхүүгийн алба /
2. СТСХ-ийн болон сумдын Санхүүгийн албаны үйл ажиллагаанд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах, нэгдсэн удирдлагаар хангах
3. Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд “Төрийн сангийн үйл ажиллагааны журам, зааврыг мөрдлөг болгож ажиллах

Аудитаар нийт 546.4 сая төгрөгийн зөрчил илэрч, аймгийн СТСХ-д 233.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, 129.6 сая төгрөгийн 5 зөвлөмж, сумдын Санхүүгийн албанд 145.6 сая төгрөгийн 6 албан шаардлага, 37.3 сая төгрөгийн 8 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Бүлэг 1:

- ✚ Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн сангийн бүтэц, зохион байгуулалт нь Төсвийн тухай хуулийн шаардлагад нийцэхгүй байна.
- ✚ Аймгийн СТСХ болон сумдын санхүүгийн албанд хүний нөөцийн тогтвор суурьшил хангалтгүй, сумдын түвшинд шаардлага, шалгуур хангасан мэргэшсэн хүний нөөц хүрэлцээгүй байна.

Бүлэг 2:

- ✚ Орон нутгийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байснаас төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн, хугацаанд нь олгох боломж бүрдээгүй байна
- ✚ Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу ерөнхийдөө хэрэгжиж байгаа боловч зарцуулалтын эрх олголт, төлбөр тооцоотой холбоотой нийтлэг зөрчлүүд давтан илэрч байна.
- ✚ Аймаг, сумдын төрийн сангууд төлбөр тооцооны хяналтын явцад санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлтийг харилцан адилгүй тайлбарлан, ялгаатай байдлаар хэрэгжүүлж байна.
- ✚ Аймгийн СТСХ, сумдын санхүүгийн албанд төлөвлөгөөт хяналт хэрэгжиж байгаа боловч нийтлэг зөрчил, дутагдал илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байгаа нь дотоод хяналт үр нөлөө хангалтгүй байгааг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн СТСХ-ийн даргад:

1. Бүртгэл, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн албан тушаалд албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага, шалгуурыг хангасан төрийн жинхэнэ албан албан хаагчийг томилох
2. Бүртгэл, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод тусгасан чиг үүргээ хэрэгжүүлж буй албан хаагчид хавсарсны нэмэгдэл 20 хувь олгосон зөрчлийг арилгах, албан тушаалын тодорхойлолтыг журам, заавартай нийцүүлэх
3. Төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжилтийг хугацаанд нь олгож, олгосон санхүүжилтийн үндсэн дээр “Орон нутгийн төсвөөс хуваарилах санхүүжилтийн эрх олгох жагсаалт /СЭБ/” маягтыг үнэн зөв хөтөлж, сар бүр баталгаажуулж хэвших
4. Сумдын санхүүгийн албанд дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдал бүрийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлон, арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих
5. Аймгийн хэмжээнд төсөвт байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам болон төлбөр тооцоотой холбоотой бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар сургалт, зөвлөгөө, мэдээллийг тогтмол зохион байгуулах

Сумдын Санхүүгийн албаны дарга нарт:

1. Төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжилтийг хугацаанд нь олгож, олгосон санхүүжилтийн үндсэн дээр “Орон нутгийн төсвөөс хуваарилах санхүүжилтийн эрх олгох жагсаалт /СЭБ/” маягтыг үнэн зөв хөтөлж, сар бүр баталгаажуулж хэвших
2. Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны зарцуулалтын эрх нээхдээ захиалагчийн шийдвэр, холбогдох хууль тогтоомж, гэрээний заалт, Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан шаардлага болон анхан шатны баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан эсэхэд хяналт тавьж, зөвхөн шаардлага хангасан тохиолдолд санхүүжилтийн эрх олгох
3. Харьяа төсөвт байгууллагуудын дансны үлдэгдлийн баталгааг хагас болон бүтэн жилийн давтамжтайгаар гаргуулан авч, тооцоо нийлж баталгаажуулан хэвших

УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитаар илэрсэн дараах асуудлыг шийдвэрлэх талаар уламжлан хүргүүлэх саналтай байна. Үүнд:

1. Төсвийн тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актад аймаг, сумын Төрийн сангийн удирдлага, харьяаллын тогтолцоог илүү тодорхой тусгаж, “дэргэд” болон “харьяанд” ажиллах ойлголтын ялгааг нарийвчлан зохицуулах
2. Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан **“Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”**-ыг Төсвийн тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн акттай уялдуулан шинэчлэн боловсруулах
3. Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.10-т заасан *“Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана”* заалтын **санхүүгийн анхан шатны баримттай тулгах** гэдэг хэсгийг аймаг, сумдын төрийн сан харилцан адилгүй ойлгож, ялгаатай байдлаар гүйлгээг хянаж баталгаажуулсан байна. Иймд Төрийн сангийн үйл ажиллагааны журамд энэ бүрдлийн шаардлагыг илүү тодорхой, нарийвчлан тусгах хэрэгцээтэй байна.
4. Төрийн сангийн төлбөр тооцооны системд зарлагын гүйлгээ хаагдсан тухайн гүйлгээг илгээх, хянах, баталгаажуулах эрхийг автоматаар хязгаарлах системийн тохиргоо нэвтрүүлэх
5. Сумдын Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуурыг Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3-д *“Төсвийн ерөнхий нягтлан бодогч нь ахлах нягтлан бодогч буюу нягтлан бодогчоор 7-оос доошгүй жил, үүнээс төвлөрүүлэн болон шууд захирагчийн ахлах нягтлан бодогчийн ажлыг 5-аас доошгүй жил эсвэл санхүү, төрийн сангийн газар, хэлтэст 3-аас доошгүй жил ажилласан, эрх бүхий мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй байх”* гэж заасан байна. Орон нутгийн түвшинд, ялангуяа сумдад дээрх шаардлагыг бүрэн хангах мэргэшсэн боловсон хүчний нөөц дутмаг байгаа нь албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг хангахад хүндрэл үүсгэж байна. Иймд орон нутгийн хүний нөөцийн бодит нөхцөл, төрийн үйлчилгээний тасралтгүй байдлыг харгалзан үзэж, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 2.1.3-т заасан **“эрх бүхий мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй байх”** шалгуурыг сумдын түвшний албан тушаалд уян хатан байдлаар зохицуулах, эсхүл үе шаттай хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.
6. ЗГСУМС болон Төрийн сангийн цахим системийн нууц үгийг задруулахгүй байх үүргийг тухайн систем хэрэглэгчид хариуцаж байна. Гэвч бодит нөхцөл байдалд төсөв захирагч, нягтлан бодогч нар гадаад томилолттой болон бусад шалтгаанаар эзгүй байгаа албан хаагчид нууц үгийг бусдад дамжуулах, эсвэл гадаад улсаас VPN ашиглан гүйлгээ хийж байгаа нь мэдээлэл алдагдах эрсдэл байгааг харуулж байна. ЗГСУМС болон төрийн сангийн цахим системийн нууц үгийн ашиглалт, хамгаалалттай холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор нууц үг дамжуулах, гуравдагч этгээдээр ашиглуулах, гадаадаас VPN ашиглан гүйлгээ хийх нөхцөлд мөрдөх хяналт, хориглолт, хариуцлагын зохицуулалтыг тодорхой тусгах
7. Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-д сумын санхүүгийн албаны хариуцах байгууллага, сангуудын чиг үүргийг тухайн үеийн бүтэц, харьяаллын дагуу тодорхойлсон боловч багийн Засаг даргын төсөв сумын Засаг даргын Тамгын газрын төсөвт нэгтгэн батлагддаг, соёл, спортын байгууллагууд аймгийн Боловсролын газрын харьяанд шилжсэн, мөн Санхүүгийн албаны даргын албан тушаалын тодорхойлолтод Сум хөгжүүлэх сан, Орон

нутгийн хөгжлийн сантай холбоотой чиг үүргийг тусгайлан хариуцахаар өөрчлөн тусгасан зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан орон тооны жишиг норматив нь бодит бүтэц, чиг үүрэгтэй нийцэхгүй болсон тул холбогдох тогтоолд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3005,
Цахим шуудан: zdtg.gsa@gmail.com,
Цахим хуудас: www.govisumber.gov.mn

2026.05.28 № А/684
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Мөн илэрсэн зөрчлийн бүртгэлтэй танилцаж, зарим асуудлуудад холбогдох тайлбарыг хүргүүлж байна.
Хавсралт 3.... хуудастай.



Т.БАТ-ЭРДЭНЭ

Амлаа аудитор
Б. Анхтүвшин
Тайлангийн
танилцагч,
тайланг хүлээн
баталгаачийн
Анхтүвшин
2026.05.28



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

200а тоот, Дансранжавын гудамж, Ганзам баг, Сүмбэр
сум, Говьсүмбэр аймаг

Утас: 77553233, Факс: 775532333

Цахим шуудан: info@sumber.gs.gov.mn

Цахим хуудас: www.sumber.gs.gov.mn

2026.05.28 № А/544

танай 2026.05.27 -ны № 147 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.
САРАНТУЯА ТАНАА

"Аудитын сэдэв батлах тухай" 2025 оны 25 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу "Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл" сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөл, аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэлийн тайлангийн төсөлтэй танилцан санал тайлбарыг хүргүүлж байна.

Хавсралт хуудастай



Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын
засаг даргын тамгын газар

Захиргаа

Засаг дарга

Эрхэмбаяр Даваадорж

2026-05-28 16:46:20

Анхны аудит
Б. Анхуу
Мэдээлэл түрүүл
Батлогдсон
28



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Лүн, Баянтал сум, Говьсүмбэр аймаг, 42040
Утас: 9409 3190, Цахим хуудас: www.bayantal.gs.gov.mn


2026.05.28 № 01/186.
танай 2026.05.27 -ны № 144 -г

Хариу хүргүүлэх тухай.

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хүлээн авчирал
Б. Мухомедов
Масалалт өгсөн
Датагосон
2026.05.28

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Төрийн сангийн тогтолцоо хууль тогтоомжийн нийцэл” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой санал, тайлбар байхгүй болно.



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, Нэрт баг,
Шивээговь сум, Говьсүмбэр аймаг, 42030

Утас/Факс: (976) 7054 6204

Цахим хуудас: www.shiveegovi.gs.gov.mn

2026.05.28 № 01/340

танай 2026.05.27-ны № 144 -1

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА
ТАНАА

Төрийн аудитын газраас ирүүлсэн “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлд хүргүүлэх санал байхгүй болно.



Ч.СУГАРМАА

Анхдугаар
Б. Анхдугаар
Мөхөөрхөн
Тогтоомжийн нийцэл

C:\Documents\B-H\TOOT.doc

2/28



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлд саналгүй гэж ирүүлсэн байна.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/16

Чойр

Аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймаг, сумдын Засаг дарга болон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын санхүүгийн албанд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын санхүүгийн албанд зөвлөсүгэй.

4. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын баг (ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг)-т үүрэг болгосугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг)-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА



D:\DOTOOD AJILTUSHAAL.doc

4226010037